

2023.01.02.

01



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 19/56

Номгон

“Баянхонгор-Тохижилт үйлчилгээ”
орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн
газрыг Баянхонгор сумын харьяанд
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Төсвийн үр ашгийг дээшлүүлэх, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох, ажлын уялдааг сайжруулах зорилгоор “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг Баянхонгор сумын харьяанд шилжүүлсүгэй.

2.“Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын бүтэц орон тоо, төсвийг Баянхонгор сумын харьяанд шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

3.“Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын бүтэц, зохион байгуулалт, дүрмийг шинэчлэн батлуулж, мөрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Баянхонгор сумын Засаг дарга (Г.Энхбаяр) үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулж, дүрэм батлах тухай 10/36 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ



0171374